



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 146

Улаанбаатар хот

“Өрийн хэрэгслийн бүртгэлд өөрчлөлт оруулж, олон нийтэд танилцуулж, анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах хугацааг сунгах тухай”

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.12, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 226 дугаар тогтоолоор баталсан “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын 3.22, 4.1, 4.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 96 дугаар тогтоолын 7 дугаар заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэс-Тавантолгой” хаалттай ХК-ийн нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийг олон нийтэд танилцуулж, захиалга авах хугацааг сунгуулах талаарх үнэт цаас гаргагч компанийн хүсэлтийг үндэслэн гаргаж буй өрийн хэрэгслийг олон нийтэд танилцуулж, анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах хугацааг 2023 оны 3 дугаар сарын 26-ны өдрийг хүртэл сунгасугай.

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 96 дугаар тогтоолоор бүртгэсэн “Эрдэнэс-Тавантолгой” хаалттай ХК-ийн хөтөлбөрийн хүрээнд нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийн гаргаагүй үлдсэн хэсэгт хамаарах төгрөгийн өрийн хэрэгслийн хүүг “хүү олгох өдөр мөрдөгдөж буй Монголбанкнаас зарласан бодлогын хүү + 4 хувь хүртэл” байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /Б.Дөлгөөн/-т үүрэг болгож, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ш.Лхагва/-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тогтоолын 1-д заасан хугацаанд өрийн хэрэгслийг олон нийтэд танилцуулан, анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулж чадаагүй тохиолдолд Санхүүгийн зохицуулах хорооноос зарагдаагүй үлдсэн өрийн хэрэгслийг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хасахыг “Эрдэнэс-Тавантолгой” хаалттай ХК /Б.Ганхуяг/, “Бидисек ҮЦК” ХК /Д.Даянбилгүүн/, “Эм Ай Си Си ҮЦК” ХХК /Х.Мөнхзул/-д тус тус анхааруулсугай.

4. Энэхүү тогтоолын 2-д заасны дагуу өрийн хэрэгслийн бүртгэлд өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хүүгийн хэмжээнд өөрчлөлт орох хугацааг хэрхэн тооцохыг олон нийтэд мэдээлэхийг “Эрдэнэс-Тавантолгой” хаалттай ХК /Б.Ганхуяг/, “Бидисек ҮЦК” ХК /Д.Даянбилгүүн/, “Эм Ай Си Си ҮЦК” ХХК /Х.Мөнхзул/, “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/-д тус тус үүрэг болгосугай.

5. Өрийн хэрэгслийн бүртгэлд өөрчлөлт оруулсантай холбогдуулан үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан дүрэм журмыг

үйл ажиллагаандаа мөрдөж, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж ажиллахыг “Эрдэнэс-Тавантолгой” хаалттай ХК /Б.Ганхуяг/-д үүрэг болгосугай.

6. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН